

ХЭНТИЙ АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН
ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДЭД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ

2011-03-14

2010 онд аймгийн ДНБ 54834,6 сая өгрөг болж, өмнөх оноос 0,2 хувиар буюу 92,7 сая төгрөгөөр өсч, нэг хүнд ноогдох ДНБ /2000 оны зэрэгцүүлэх үнээр/ 781,3 мянган төгрөг болж, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг сүүлийн 3-н жил дараалан давуулан биелү үлж, энэ хэмжээгээр орон нутгийн бүтээн байгуулалтанд зарцуулагдсан хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдсэн байна. Мөн орон нутгийн өсөвт 5567,6 сая төгрөгийн орлого төвлөрүүлэн, орон нутгийн зарлагаас давсан 358,5 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. 2009, 2010 оны гүйцэтгэлээр **орлогын өсөлт зарлагын өсөлтөөс түрүүлж**, төсвийн урсгал болон нийт тэнцэл сайжирсан байна.

Хэнтий аймагт 2008 онд 5700,0 сая өгрөгийн хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажил хийгдэж байсан бол 2009 онд 17100,0 сая өргөгийн, 2010 онд 32821,9 сая өгрөгөөр хөрөнгө оруулалтын ажил хийгдэж, хөрөнгө оруулалт жилээс жилд нэмэгдэж байна. Дээрх хөрөнгө оруулалтуудаас 2010 онд орон нутгийн төсвийн эх үүсвэрээр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын дүн 1186,2 сая төгрөг болж, өмнөх оноос 835,0 сая төгрөгөөр буюу 3,4 дахин өссөн байна.

Орон нутгийн урсгал өсөв сүүлийн 2 жил дараалан өргүй гарч, урсгал төсвийн авлага 13,2-21 хувиар бууран, 2010 оны жилийн эцсийн мэдээгээр орон нутгийн төсөв 10,9 сая төгрөгийн авлагатай байгаа нь өмнөх оноос 21,0 хувиар буурсан дүнтэй байна.

Нийгмийн үзүүлэлтийн хувьд боловсролын салбарт хамран сургалт, багш нарын хангалтын хувь ахисан, нэг компьютерт ногдохүүхдийн тоо буурсан байна. Мөн ажилгүйдэл ядуурлын түвшин өнгөрсөн онтой харьцуулахад 0,1 -2,6 хувиар, шилжилт өдөлгөөний цэвэр коэффициент 1,2 хувиар тус тус буурсан, эхийн эндэгдэл гаралт, урлагийн байгууллагуудад шинээр тавьсан бүтээлийн тоо 19,3 хувиар ахисан, нялхсын эндэгдлийн түвшин буурсан зэрэг сайн үзүүлэлтүүд байгаа боловч 5 үртэлх насны хүүхдийн эндэгдэл өнгөрсөн онтой харьцуулахад 8-аар нэмэгдэж, халдварт өвчний гаралт нилээд нэмэгдсэн нь өрөг үзүүлэлт болж байгаад дүгнэлт хийх шаардлагатай байна.

2010 онд ЖДҮ -ийн тоо 12-оор нэмэгдэж, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хэмжээ эрс өссөн байна. Өндөрхаан хотын дэргэд хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулж, хог хаягдлыг дахин боловсруулах жижиг үйлдвэр ашиглалтанд оруулсан нь үр дүнтэй ажил болсон байна. Мөн энэ онд ашиглалтанд оруулсан хатуу хучилттай зам, шинээр ашиглалтанд оруулсан орон сууц, цэвэр бохир усны өвлөрсөн хангамжид хамрагдсан айл өрхийн тоо өмнөх жилүүдээс нэмэгдсэн нь иргэдийн ая тухтай амьдрах орчин сайжирч байгаагийн илрэл гэж үзэхээр байна.

Аймгийн эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн нийт дундаж оноо 4,4 байна.